



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Албан томилолтоор ажиллуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад улсын Гуанжоу хотод 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулах “Canton fair 2023” барилгын материалын олон улсын үзэсгэлэнд дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж судлах, үйлдвэрлэгчидтэй холбоо тогтоох, хамтран ажиллагч байгууллагуудад танилцуулга мэдээлэл бэлтгэх зорилгоор Ахлах мэргэжилтэн Нацагдоржийн Пүрэвсүрэн, Инженер Батсайханы Батбилэгийг томилон оролцуулсугай.

2.Улаанбаатараас Замын-Үүд хүртэлх ирж, очих хоол, унааны зардалд шаардагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг дотоод томилолтын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Албан томилолтын тайланг ажлын 5 хоногийн дотор гаргаж удирдлагад танилцуулахыг Б.Батбилэгт үүрэг болгосугай.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ